

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.06.06

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 06 сарын 06

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,120.53	-0.017%	9.531%	9.543%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.017 хувиар суларлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банкнаас интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна. Оны эхнээс тооцвол өнгөрсөн ам.долларын ханш төгрөгийн эсрэг суларсан анхны долоо хоног байлаа.


Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 31 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Банкнууд 10 сая ам.долларын своп хэлцэл байгуулах саналыг 2 удаа ирүүлсэн ч Монголбанк биелүүлээгүй байна.



Гадаад худалдаа:

БНХАУ-д ирэх саруудад нүүрсний үнэ буурах төлөвтэй байгааг SxCoal мэдэгдлээ. Тодруулбал, өнгөрсөн улиралд БНХАУ-ын түүвэр судалгаанд оролцсон 88 уурхайн нүүрсний нөөц 4.4 хувиар, ӨМӨЗО-д үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудын нөөц 18.6 хувиар буурсан байна. Үүнээс үзэхэд уурхайнуудад борлуулахад бэлэн байгаа их хэмжээний нүүрс байгаа юм байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 6

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	102.14	0.82%	-2.3%	12.32%
EURUSD	1.0718	-0.54%	1.59%	-12.06%
USDCNY	6.6525	-0.08%	-0.17%	4.03%
USDRUB	60.95	-2.09%	-12.18%	-16.3%
USDJPY	130.6	2.37%	0.01%	19.53%
AUDUSD	0.7204	0.10%	1.78%	-7.09%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс нөлөөллөө.

- Nonfarm Payrolls буюу АНУ-ын хөдөө аж ахуйн салбараас бусад салбарын ажил эрхлэлтийн тоон мэдээлэл эерэг үзүүлэлттэй гарлаа. 5 сард шинээр 390 мянган ажлын байр бий болж шинжээчдийн таамаглалыг эвдсэн бөгөөд хөдөлмөрийн зах тогтвортой байх нь Холбооны Нөөцийн Санд бодлогын хүүг нэмэгдүүлэх орон зайг олгож байна.
- Шинэ ажлын байрны тоон мэдээлэл сайн гарсан ч АНУ-ын ажилгүйдлийн түвшин шинжээчдийн таамаглалаас муу гарлаа. Тодруулбал, 5 сард АНУ-ын ажилгүйдлийн түвшин 3.6 хувийн өсөлттэй гарсан буюу шинжээчдийн таамаглаж байсан 3.5 хувиас өндөр гарлаа.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 6/Jan/2022 - 2:46:14 GMT. Powered by TradingView.
US Dollar Index Futures, (CFD):DX, D



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.